

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
1.3. Төслийн үйл ажиллагааны мэдээлэл (ТЭЗҮ-д тусгагдсанаар)	4
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	5
2.1.1. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх	6
2.1.2. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор	6
2.1.3. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар	7
2.1.4. Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утаа	8
2.2.1. Усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	10
2.2.2. Ундны усыг тогтсон хугацаанд тогтмол шинжлүүлэх.....	10
2.3.1. Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, хадгалах	11
2.3.2. Шимт хөрсийг алдагдахаас хамгаалж хадгалах.....	11
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	15
ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	16
4.1. Уул уурхай, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр үүссэн гуу жалга, нүх, ухашнуудад техникийн нөхөн сэргээлт хийх	17
4.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах.....	18
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	19
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	20
ДОЛОО. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	21
7.1. Уурхайн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах.....	22
НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	23
8.1. Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	24
8.2. Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.....	24
8.3. Хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах.....	25
8.4. Бүх нийтийн цэвэрлэгээг тогтсон хугацаанд хийх.....	25
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	26
9.1. Усны чанарын судалгаа	26
9.1.1. Хээрийн судалгаа.....	26
9.1.2. Судалгааны үр дүн	27
9.2. Хөрсөн бүрхэвч	27

9.2.1. Хээрийн судалгааны арга зүй	27
9.2.2. Лабораторийн судалгааны арга зүй	28
9.2.3. Судалгааны үр дүн	28
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	32
10.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	32
10.2. Кэмпийн оршин суугч болон автобаазын ажиллагсдад байгалийн ургамал талхлахгүй олон салаа зам үүсгэхгүй байх, шатах тослох материалын асгаралтын үед авах арга хэмжээний тухай болон бусад байгаль орчны холбогдолтой заавар зааварчилгаа, нийт ажиллагсдад ХХАА-ны ээлжит зааварчилгаагаар орох	32
10.3. Орон нутгаас ажилтан авч ажиллуулах	32
10.4. Багийн иргэдийг өвөлжилт хүндэрсэн нэхцөлд өвс, тэжээлээр хангах.....	32
10.5. Багийн иргэдээс уурхайн хүнсний хэрэгцээнд зах зээлийн үнээр мах худалдаалан авах.....	32
10.6. Төлөвлөгөөнөөс гадуур удирдалга зохион байгуулалтын түвшинд хийсэн ажлууд.....	32
АРВАН НЭГ. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	33
10.1. Төрийн захиргааны төв байгууллагууд /Орон нутгийн БОАЖГ, бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар/.....	33
10.2. БОАЖЯ-нд жилийн эцэст А/618 журмын дагуу орон нутгаас төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлтийг авч хавсарган төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлнэ	33
10.3. Иргэд олон нийтэд хагас жил болон жилийн эцэст тайлангийн хэрэгжитийг танилцуулах.....	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	5
Хүснэгт 2-2. Усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	9
Хүснэгт 2-3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөө	11
Хүснэгт 2-4. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөө.....	13
Хүснэгт 2-5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөө	14
Хүснэгт 3-1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт	15
Хүснэгт 4-1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах т.....	16
Хүснэгт 4-2. Дүйцүүлэн хамгаалах талбайн эргэлтийн цэг	17
Хүснэгт 7-1. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	21
Хүснэгт 8-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	23
Хүснэгт 9-1. Хөрсний дээжний үзүүлэлтүүдийг шинжилсэн арга зүй, стандарт	27
Хүснэгт 10-1. Орон нутгийн ажилчдын мэдээлэл.....	32


ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Төслийн талбайн байршил.....	4
Зураг 2-1. Талбайн үсалгаа.....	6
Зураг 2-2. Хүрдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээ	6
Зураг 2-3. Хүрдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээ	7
Зураг 2-4. Зам талбайн, арчилгааны ажил хийгдэж буй байдал.....	7
Зураг 2-5. Олборлолтонд өртсөн талбай	12
Зураг 2-6. Шимт хөрсний овоолгын талбай	12
Зураг 4-1. Нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг.....	17
Зураг 4-2. Төслийн талбайд тарьж ургуулсан мод.....	18
Зураг 4-3. Төслийн талбайд тарьж ургуулсан моды	19
Зураг 4-4. Төслийн талбайд тарьсан сухайн бүт.....	19
Зураг 7-1. АА-ы зааварчилгаа орж буй байдал.....	22
Зураг 8-1. Дахивар хог хаягдал	24
Зураг 8-2. Хаягдал тос ачуулж буй байдал.....	24
Зураг 8-3. Бүх нийтийн цэвэрлэгээ.....	25
Зураг 9-1. Хүнцэлийн агууламж.....	30
Зураг 9-2. Хром (Cr)-ын агууламж	30
Зураг 9-3. Хар тугалга (Pb)-ны агууламж мг/кг.....	31
Зураг 10-1. Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалт.....	33
Зураг 10-2. Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалт.....	34

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Эрдгео” ХХК нь Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг харьяалагддаг бөгөөд Улаанбаатар хотоос зүүн тийш 296 км-т, Өлзийт сумаас зүүн хойш 42 км-т “Нүхтийн булаг” хэмээх газарт байрладаг.



Зураг 1-1. Төслийн талбайн байршил

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хэрэгжүүлэгч:

“Эрдгео” ХХК

Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар:

2011004028

Регистрийн дугаар:

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Тээвэрчдийн гудамж-27, Жигүүр гранд оффис, 5 давхар, 11 тоот

Утас:

+(976) 99102445

1.3. Төслийн үйл ажиллагааны мэдээлэл (ТЭЗҮ-д тусгагдсанаар)

Ил уурхайн хүрээ: Хүдрийн биетүүдийг ашиглах ил уурхайн хувьд 1190-р үнэмлэхүй түвшин хүртэл ашиглана. Ил уурхай нь баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон ба ил уурхайн амсрын өргөн 110-210 м, урт 420 м, уурхайн ёроолын өргөн 20 м, урт 110 м байна. Ил уурхайн нээлтийн траншейн эхлэл цэгийн солбицол $X=617240.9$, $Y=5013414.0$ байна.



ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 2-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

Бүлэг	Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр						
2.1.1	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн дотоод болон тээврийн зам	0.0	Төслийн талбайд тоосжилтыг бууруулах зорилгоор цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан дулааны улиралд тогтмол усалгаа хийж ажиллаж байна (Зураг 2-1).	100%
2.1.2		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах – хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх (Хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах)	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна замууд	200.0	Уурхайн дотоод зам талбай болон тээврийн зам дагуу холбогдох тэмдэг тэмдэглэгээнүүдийг байрлуулах, тэдгээрийн арчилгааг тогтмол хийдэг (Зураг 2-2, 2-3).	100%
2.1.3		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа тогтсон хуваарийн дагуу хийх		Дотоод төлөвлөлт	Үер ус болон техник хэрэгсэлийн нөлөөгөөр зам талбай эвдрэлд орсон тохиолдолд зам талбайн арчилгааны ажлыг тухай бүр авч хэрэгжүүлж ажиллаж байна (Зураг 2-4).	100%
2.1.4	Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникүүд агаар орчныг бохирдуулж болзошгүй нөлөөлөл	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Бутлуур орчим	Дотоод төлөвлөлт	Төслийн үйл ажилалгаанд ашиглаж буй техник хэрэгсэлийг тогтмол үзлэгт хамруулж ажиллаж байна.	100%
	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажилд зарцуулсан нийт зардалын хэмжээ			Мян.төг	200.0	

2.1.1. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх

Төслийн талбайд тоосжилтыг бууруулах зорилгоор цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан дулааны улиралд тогтмол усалгаа хийж ажиллаж байна.



Зураг 2-1. Талбайн усалгаа

2.1.2. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх

Хурд хэтрүүлэхгүй байх, технологийн бус замаар тээвэр хийх зэргийг жолооч нарт тогтмол анхааруулж хяналт тавьж ажиллаж байна.

Уурхайн дотоод зам талбай болон тээврийн зам дагуу холбогдох тэмдэг тэмдэглэгээнүүдийг байрлуулах, тэдгээрийн арчилгааг тогтмол хийдэг.



Зураг 2-2. Хурдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээ



Зураг 2-3. Хурдны хязгаарлалтын тэмдэг, тэмдэглэгээ

2.1.3. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа тогтсон
хуваарийн дагуу хийх



Зураг 2-4. Зам талбайн, арчилгааны ажил хийгдэж буй байдал

Үер үс болон техник хэрэгсэлийн нөлөөгөөр зам талбай эвдрэлд орсон тохиолдолд зам талбайн арчилгааны ажлыг тухай бүр авч хэрэгжүүлж ажиллаж байна.

2.1.4. Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах

Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгслийг тогтмол үзлэгт хамруулж ажиллаж байна.



Хүснэгт 2-2. Усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Бүлэг	Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
2.2. Усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт						
2.2.1	Усны менежментийн төлөвлөлтийг зөв оновчтой гаргаагүйгээс уурхай үйл ажилагаанд усыг урт хугацаанд хэмнэлт, дахин ашиглалтгүй ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учрах	Уурхайн нийт усны ашиглалт, эргүүлэн ашиглах усны хэмжээг зорилтот түвшинд байлгах.	Уурхайн нийт ажилчид	896.524	Уурхайн ус ашиглах дүгнэлтийг гаргуулж, гэрээ байгуулан төлбөрийг хуулийн хугацаанд төлж ажиллаж байна. Унд ахуй болон зам талбайн усалгаанд ус ашигладаг. Тайлангийн хавсралт хэсэгт ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, төлбөр төлсөн баримтыг хавсаргав.	100%
		Уурхайн үйл ажиллагаатай холбоотой усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	Уурхайн талбай			100%
2.2.2	Ундны усны чанар алдагдах	Ундны усыг тогтсон хугацаанд тогтмол шинжлүүлэх	Уурхайн гүний худаг	600.0	Унд ахуйн уснаас 2024 онд 2 удаа усны дээж авч шинжилгээнд өгч ажилласан. Шинжилгээний үр дүнг тайлангийн орчны хяналт шинжилгээний үр дүнгийн хэсэгт дэлгэрэнгүй тусгаж өгсөн болно.	100%
	Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажилд зарцуулсан нийт зардалын хэмжээ			Мян.төг	1,496.5	

2.2.1. Усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах

2024 оны 05 дугаар сарын 21-ий өдөр Дундговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраар 16 тоот ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж 2024 оны 07 дугаар сарын 01-ий өдөр түс дүгнэлтийн дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газартай ус ашиглах гэрээ байгуулсан. Ус ашигласны төлбөр болох 896,524.8 (Найман зуун ерэн зургаан мянга таван зуун хорин дөрөв) төгрөгийг тушаасан.

Мөн сургалт, зааварчилгаагаар дамжуулж нийт ажилчдын дунд ус ашиглалттай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна.

2.2.2. Ундны усыг тогтсон хугацаанд тогтмол шинжлүүлэх

Унд ахуйн уснаас дээж авч “Ханлаб” ХХК-ий лабораториор шинжлүүлсэн. Шинжилгээний хариуны үр дүнг тайлангийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дэлгэрэнгүй тусгасан. Мөн түүнчлэн шинжилгээний хариуг тайланд хавсралтаар оруулсан.

Хүснэгт 2-3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт

Бүлэг	Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
2.3. Газрийн хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах						
2.3.1.	Хөрсөн бүрхэвчийг хөндөж хуулах хадгалах	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, хадгалах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төлөвлөлт	Шимт хөрсийг БОННУ-ий хөрсний бүлэгт заасаны дагуу тогтсон гүнд хуулан, MNS 5916 : 2008 стандартын дагуу хуулж, хадгалж байна (Зураг 2-5, 2-6).	100%
2.3.2.		Шимт хөрсийг алдагдахаас хамгаалж хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Дотоод төлөвлөлт	2.3.1-т заасаны дагуу овоолгын стандартын дагуу барьж байгуулж ажиллаж байна (Зураг 2-5, 2-6).	100%
	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажилд зарцуулсан нийт зардалын хэмжээ			Мян.төг	Дотоод төлөвлөлт	

2.3.1. Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, хадгалах

Бид одоогоор 30.31 га талбайд уулын ажил хийж, 1.53 га талбайд 70,786 м³ шимт хөрсний овоолго үүсгэсэн байна.

2.3.2. Шимт хөрсийг алдагдахаас хамгаалж хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих

MNS 5916:2008 стандартын дагуу шимт хөрсний овоолгыг зөв үүсгэж, хадгалалт, хамгаалалт дээр тогтмол хяналт тавьж ажиллаж байна.



Зураг 2-5. Олборлолтонд өртсөн талбай



Зураг 2-6. Шимт хөрсний овоолгын талбай

Хүснэгт 2-4. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт

Бүлэг	Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
2.4. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах						
2.4.1.	Ургамлан нөмрөг, тэдгээрийн зүйлийн олон янз байдалд нөлөөлөх	Ургамалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд ажиглалт судалгаа хийх	Уурхайн тусгай зөвшөөрлийн талбай	300.0	Төслийн талбайд 7 дугаар сард нэг удаа төслийн талбайд судалгааны цэг сонгон ургамалжилтын судалгааг хийсэн. Тайлангийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.	100%
	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажилд зарцуулсан нийт зардалын хэмжээ			Мян.төг	300.0	

Хүснэгт 2-5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт

Бүлэг	Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
2.5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах						
2.5.1.	Уурхайн дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбайн дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих талаар жолооч нарт сургалт явуулах	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлт	Сургалтаар дамжуулан олгож байна.	100%
2.5.2.	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус агнуур, шувууд цахилгаанд цохиулах, цахилгааны утас мөргөх гэх мэтээр үхэж, хорогдох эрсдэлтэй	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай хууль дүрэм, журмын тухай сургалт явуулах үзлэг шалгалт хийдэг харуул хамгаалалтын ажилчдад мэдээлэл өгөх	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлт	Харуул хамгаалалтын ажилчдад чиглэл өгч Монгол улсын хууль дүрэм журмын дагуу шалгалт үзлэгийг тогтмол хийлгэж ажиллаж байна.	100%
2.5.3.	Хур бороо багатай, ган зудтай үед зэрлэг амьтан үхэж хорогдох	Ган зуд болон байгалийн цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд зэрлэг амьтдыг хамгаалах Биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	Өлзийт сумын нутагт	Дотоод төлөвлөлт	Загийн ус хэмээх газар уст цэг гаргахаар гэрээ хийж, цооногийн зөвшөөрөл хүссэн материалыг холбогдох газарт хүргүүлсэн.	0%
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажилд зарцуулсан нийт зардалын хэмжээ				Мян.төг	0.0	



ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 3-1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

Бүлэг	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
3.1.	Техникийн нөхөн сэргээлт	Бүрэн ашиглаж дууссан талбайн газрын дээрх болон доорх хог хаягдал, элдэв үлдэгдэл материалаас цэвэрлэж, шимт болон шимэрхэг хөрсийг дэс дарааллаар нь буцаан дүүргэлт хийж, өнгөн хөрс дэвсэж хэлбэршүүлэх, самнах.	Төслийн талбай	6'600.0	Ашиглахаа больсон технологийн зам талбайд техникийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн. Нөхөн сэргээлтийн актын хавсаргав.	100%



ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 4-1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт

Бүлэг	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
4.1.	Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Уул уурхай, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр үүссэн гуу жалга, нүх, ухашнуудад техникийн нөхөн сэргээлт хийх /орон нутгаас төлөвлөж өгсөн талбайд/	Өлзийт сум 5-р багийн нутагт байрлах Цагаан хад хэмээх газар	3,000.0	Дүйцүүлэн хамгааллын талбай орчмын мал амьтны сэг зэм булж устгаж 1 га талбайн овоолго тэгшлэх техникийн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулсан. Актыг тайланд хавсаргасан.	100%
4.2.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж ажиллах	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах	“Эрдгео” ХХК-ийн уурхайн тосгоны ойр орчимд	2,000.0	Төслийн талбайд 100 ширхэг хайлаас, 50 ширхэг сүхэй тарьж ургуулсан. Арчилгаа усалгааг тогтмол хийж ажиллаж байна.	100%

4.1. Уул уурхай, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр үүссэн гуу жалга, нүх, ухагнуудад техникийн нөхөн сэргээлт хийх

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тус газрын ойр орчимд хаягдсан 4200 ш малын сэг зэм булж устгах, овоолго шороог тэгшилж 1 га талбайд нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулж ажиллаа.

2024 оны 06 дугаар сарын 15-ий өдөр Өлзийт сумын Засаг даргын тагмгын газартай акт үйлдэж дүйцүүлэн хамгаалах талбайг хүлээлгэж өгсөн.

Хүснэгт 4-2. Дүйцүүлэн хамгаалах талбайн эргэлтийн цэг

Д/д	Эргэлтийн цэг	
	Өргөрөг	Уртраг
1	106°31'01.42"	45°15'03.53"
2	106°29'20.57"	45°15'03.53"
3	106°29'01.42"	45°15'16.57"
4	106°31'01.42"	45°15'16.57"



Зураг 4-1. Нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг

4.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд уурхайн ажилчдын тосгон орчим 100 гаруй хайлаас, сухай шинээр нэмж тарьж суулгасан ба өмнөх тарсан модны арчилгаа хамгааллыг тогтмол хийж ажиллаж байна.

Бид говь цөлийн бүс нутагт ургах чадвартай мод бут сөөгийг сонгон төслийн талбайд тарьж ургуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



Зураг 4-2. Төслийн талбайд тарьж ургуулсан модыг мэрэгч амьтад идэхээс хамгаалсан байсан



Зураг 4-3. Төслийн талбайд тарьж ургуулсан модыг мэргэч амьтад идэхээс хамгаалсан байсан



Зураг 4-4. Төслийн талбайд тарьсан сухайн бут

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Газар чөлөөлж нүүлгэн суурьшуулах асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжид төлөвлөгөө хийхийг шаарддаггүй, харин Дэлхийн Банкны ҮАБ/ББ 4.12-ын шаардлагад нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, ядаж л хамгийн багаар нүүлгэн суурьшуулах хувилбарыг санал болгохыг заасан байдаг. 2024 онд “Эрдгео” ХХК-ийн ашиглалтын талбайтай давхцалтай айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024 онд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөхгүй. 2021 онд хийсэн археологи, палентиологийн судалгаагаар түүх соёлын өвд хамаарах дурсгал илрээгүй. Түүх соёлын өвд хамраарах зүйл илэрсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний мэдлэгийг сургалтаар нийт ажилчдад олгож ажиллана.



ДОЛОО. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 7-1. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Бүлэг	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
7.1.	Гал түймэр	Уурхайн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламжууд, техник хэрэгсэл, кемп аж ахуйн хэсэг		Галын хорыг шаардлагатай объектуудад байрлуулах, тэдгээрийн үзлэг шалгалтыг тогтмол хийх (Зураг 7-1).	100%
7.2.		Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан, албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Эрдгео ХХК-ийн бүх ажилчид		Гал түймрээс урьдчилсан сэргийлэх сургалтыг ажилчдын дунд зохион байгуулдаг (Зураг 7-1).	100%
7.3.	Автомашин, техникийн осол	Уурхайн дотоод болон тээврийн замд аюулгүй байдлын дүрэм, журмыг тогтмол хангаж, хяналт тавьж ажиллах	Уурхайн жолооч, операторууд		ХАБЭА-н ажилтанууд сургалт, зааварчилгаагаар дамжуулан тогтмол үүрэг чиглэл өгч ажиллаж байна (Зураг 7-1).	100%
7.4.	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, ХХАА-ны тухай ойлголтгүйн улмаас үүсэх осол эрсдэл	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэнд хяналт тавих	Нийт ажилчдад			100%
7.5.		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Нийт ажилчдад			100%
7.6.		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэлээр бүрэн хангах	Нийт ажилчдад		Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр бүрэн хангаж ажилладаг.	100%

Бүлэг	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
7.7.	Байгалийн хүчин зүйлстэй холбоотой гэнэтийн аюул осол	Цаг агаарын улирлын, 7 хоногийн, сарын, өдөр тутмын мэдээг гаргаж ажилдад танилцуулах	Уурхайн нийт ажилчид		Цаг агаарын урьдчилсан мэдээг 7 хоног бүрээр гаргаж уурхайн мэдээллийн самбарт байрлуулж ажилчдын аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна.	100%

7.1. Уурхайн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах

Төслийн талбайд ажиллаж байгаа нийт ажилчдын дунд галын аюулаас сэргийлэх сургалтыг зохион байгуулж, ХАБ-ын өдөр тутмын зааварчилгаагаар дамжуулан галын аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай зааварчилгааг тогтмол өгч ажиллаж байна. Шаардлагатай объектуудад галын хор, гал унтраах багаж хэрэгсэлүүдийг байрлуулсан байна.



Зураг 7-1. АА-ы зааварчилгаа орж буй байдал



НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 8-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Бүлэг	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал (мян.төг)	Биелэлт	Биелэлт (%)
8.1.	Ахуйн болон үйлдвэрийн	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	Дотоод төлөвлөлт	Төслийн үйл ажиллагаанаас гарч буй дахивар хог хаягдлыг цуглуулан түүхий эд авах цэгт нийлүүлж байна.	100%
8.2.	Аюултай хог хаягдал	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Төслийн хүрээнд	Дотоод төлөвлөлт	Төслийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал тосыг “Саус ресурс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу нийлүүлж ажиллаж байна. 2024 онд нийт 3.4 тонн хаягдал тосыг нийлүүлсэн байна.	100%
8.3.	Ахуйн болон аюултай	Батлагдсан маягт болон “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах	Төслийн хүрээнд	Дотоод төлөвлөлт	Төслийн үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлын бүртгэлийг тогтмол хөтөлж ажиллаж байна.	
8.4.	Ахуйн хог хаягдал	Бүх нийтийн цэвэрлэгээг тогтсон хугацаанд хийх	Уурхайн нийт ажилчид	Дотоод төлөвлөлт	2024 онд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг 1 удаа зохион байгуулсан байна.	
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан нийт зардал			Нийт зардал (мян.төг)	0.0	

8.1. Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

Төслийн үйл ажиллагаанаас гарч буй ахуйн хог хаягдлыг хаягдал цуглуулах цэгт цуглуулж дахин боловсруулах цэгт нийлүүлж ажиллаж байна.



Зураг 8-1. Дахивар хог хаягдал

8.2. Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах

Төслийн үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлыг төслийн талбайд түр хадгалж АХХаягдал устгах, тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний дагуу нийлүүлж ажиллаж байна. Манай компани 2024 оны 08 дугаар сарын 03-нд Саус ресүрс ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 3.2 тонн хаягдал тосыг нийлүүлсэн байна.



Зураг 8-2. Хаягдал тос ачуулж буй байдал

8.3. Хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах

Батлагдсан маягтын дагуу аюултай хог хаягдлын бүртгэлийг хийж техникийн ашигласан тос, хаягдал аккумулятор тээвэрлэх, цуглуулах, хадгалах, устгах үйл ажиллагаанд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын баримт бичиг, бусад мэдээллийн нэгтгэлийн хүснэгтийг бөглөж аймгийн байгаль орчны газарт илгээж ажиллаж байна.

8.4. Бүх нийтийн цэвэрлэгээг тогтсон хугацаанд хийх

Төслийн талбайн хэмжээнд 1 удаа бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан байна.



Зураг 8-3. Бүх нийтийн цэвэрлэгээ

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

9.1. Усны чанарын судалгаа

9.1.1. Хээрийн судалгаа

Усны чанарт хяналт шинжилгээ хийх зорилгоор 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдөр үнд ахуйн уснаас 1 сорьц авч Ханлаб ХХК-ий лабораториор усны ерөнхий химийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулав.

Усны чанарын үнэлгээ - Гадаргын усны химийн чанар, найрлагыг үнэлэхдээ гол ионуудын агууламжийг үндэслэн О.А.Алекины ангиллыг ашигласан.

Тус ангиллаар

Анионы зонхилох байдлаар нь:

- Гидрокарбонат, карбонат
- Сульфат
- Хлорид

Катионы зонхилох байдлаар

- Кальци
- Магни
- Натрийн гэж тус тус ангилдаг бөгөөд дараах 4 төрөлд хувааж авч үзнэ. Үүнд:

1-р төрөл: $\text{HCO}_3^- > \text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+}$ (энэ төрлийн ус нь ихэвчлэн сул шүлтлэг, цэнгэг, зөөлөн шинж чанартай байна)

2-р төрөл: $\text{HCO}_3^- < \text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+} < \text{HCO}_3^- + \text{SO}_4^{2-}$ (энэ төрөлд бага эрдэсжилт бүхий нуур, голын ус багтдаг)

3-р төрөл: $\text{HCO}_3^- + \text{SO}_4^{2-} < \text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+}$ эсвэл $\text{Cl}^- > \text{Na}^+ + \text{K}^+$ (энэ төрлийн усанд далай, тэнгис, эрдэсжилт ихтэй ус багтана)

4-р төрөл: $\text{HCO}_3^- = 0$ (энэ төрлийн ус нь хүчиллэг бөгөөд ихээхэн бохирдсон уул уурхай болон үйлдвэрийн ус багтдаг)

Усны хатуулаг: Усны хатуулгийг ууссан кальци (Ca^{2+}) болон магнийн (Mg^{2+}) ион үүсгэдэг ба нийт хатуулгийн хэмжээ нь кальци, магнийн ионы концентрацийн нийлбэрээр тодорхойлогдоно. (Дорж, 2005). Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарт -д хатуулгийн зөвшөөрөгдөх хүлцэх дээд агууламж 7 мг-экв/л байдаг бол хатуулгийн зэргээр 1.50 мг-экв/л-ээс бага бол маш зөөлөн, 1.51 – 3.00 мг-экв/л бол зөөлөн, 3.01 – 5.00 мг-экв/л бол зөөлөвтөр, 5.01 – 7.00 мг-экв/л бол хатуувтар, 7.01– 9.00 мг-экв/л хатуу, 9.01 мг-экв/л -ээс их бол маш хатуу гэсэн ангилалд тус тус хамаарагдана.

Усны эрдэсжилт: Усны эрдэсжилтийг нийт катион болон анионы нийлбэрээр тодорхойлох ба Монгол Улсын ундны усны MNS 0900:2018 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээ 1000 мг/л-ээс ихгүй байна. Байгалийн усыг эрдэсжилтээр нь ангилсан олон ангилал байдгаас А.М.Овчинниковын ангиллыг ерөнхийд нь баримтлан үнд, ахуйн болон малын усны нормыг харгалзан дараах байдлаар ангилдаг. Эрдэсжилт нь 200 мг/л-ээс бага байвал нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй, 210 – 500 мг/л бол цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, 510-

1000 мг/л бол цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, 1100-3000 мг/л бол давстайвтар буюу их эрдэсжилттэй, 3000 – 7000 мг/л бол давстай буюу шорвогдуу, 7100 мг/л-ээс дээш бол их давстай буюу шорвог гэсэн ангилалд хамаарагдана².

Усны чанарыг үнэлэхдээ Монгол Улсын Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага чанар, байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарт болон Усан орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлага MNS 4586:1998 стандартуудыг баримталдаг. Харин бохир усны микробиологийн үзүүлэлтийг үнэлэхдээ MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Хаягдал усны ерөнхий шаардлага стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг баримтална.

9.1.2. Судалгааны үр дүн

Химийн шинжилгээний үр дүн: Шинжилгээнд авсан 1 хүдгийн 7 дугаар сарын шинжилгээний хариуны дүгнэлт.

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, сул шүлтлэг, I төрлийн, цэнгэг, зөөлөвтөр ус байна. Химийн шинжилгээний үр дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 (цаашид MNS0900:2018 гэх) стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд стандартад заагдсан дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

Усны эрдэсжилт: Судалгааны талбайн усны эрдэсжилтийг MNS 4586 : 1998 болон MNS 0900 : 2008-ын хүлцэх агууламжтай харьцуулахад 210-500мг/г дунд зэргийн эрдэсжилттэй ангилалд хамаарагдана.

Ерөнхий хатуулаг: Уст цэгийн сорьцын химийн шинжилгээний дүнг MNS 900:2018 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд хатуулагын хувьд зөөлөвтөр ангилалд (3.87 мг-экв/л) хамаарагдаж байна.

9.2. Хөрсөн бүрхэвч

9.2.1. Хээрийн судалгааны арга зүй

Хээрийн судалгаагаар судалгааны талбайтай танилцах, хөрсний төлөөлөл болохуйц цэгүүдэд зүсэлт тавих, GPS-ийн хэмжилт авах, гадаргын болон хөрсний морфологи бичиглэл хийх, дээж авах зэрэг үйлдлийг гүйцэтгэхээс гадна тухайн талбайтай холбоотой хөрсний судалгааны материалтай танилцах хэрэгтэй байдаг.

Эдгээр материал нь судалгааны талбайн талаарх хамгийн дэлгэрэнгүй, бодит мэдээлэл болох ба хөрсний төлөв байдал, доройтлыг тодруулах суурь материал юм.

Хүснэгт 9-1. Хөрсний дээжний үзүүлэлтүүдийг шинжилсэн арга зүй, стандарт

Үзүүлэлт	Аргазүй	Стандарт
Дээж бэлтгэх, хатаах	Хуурай аргын нөхцөлд	Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 3310:1991
Дээж шигших	1 мм	
pH	Хөрс:ус (1-2.5), pH метр	Хөрсний чанар, pH-ыг тодорхойлох MNS ISO 10390-2001
CaCO ₃	Кальциметр, эзлэхүүний	Хөрсний. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга. MNS 3310 : 1991
Цахилгаан дамжуулах чадвар	Хөрс:ус (1-2.5), ЕС метр	
Органикийн агууламж	Тюрины, Бихроматын исэлдэлт	

Хөдөлгөөнт фосфор, Кали	Мачигины арга	
Механик бүрэлдэхүүн	Пипеткийн арга	Качинскийн арга
Хүнд металл	Спектрометрийн арга	
Нянгийн бохирдол		

9.2.2. Лабораторийн судалгааны арга зүй

Хөрсний үржил шимт чанарын үзүүлэлтүүдийн түвшнийг олон улсын хэмжээнд ашигладаг үр дүнгийн зэрэглэлийн аль түвшинд байгааг тодорхой харуулах, үнэлэхийг зорилго.

а) Хөрсний урвалын орчин: урвалын орчныг дараах зэрэглэлд ангилдаг (Soil survey manual. 1993. Chapter-3)

pH	5.6-6.0	6.1-6.5	6.6-7.3	7.4-7.8	7.9-8.4	8.5-9.0
Түвшин	Дунд зэрэг хүчиллэг	Сул хүчиллэг	Саармаг	Сул шүлтлэг	Дунд зэрэг шүлтлэг	Хүчтэй шүлтлэг

б) Хөрсний ялзмагийн агууламж: Олон улсын практикт хөрсний ялзмагийн агууламжаар нь маш бага буюу <1%, бага буюу 1-2%, дунд буюу 2-5%, их буюу >5% гэж хуваан авч үздэг (<https://njaes.rutgers.edu/soil-testing-lab/organic-matterlevels.php>)

с) Карбонатын агууламж: Үржил сайтай хөрсөнд карбонат илэрдэггүй.

Карбонат	0	0.1-2	2-10	10-25	>25
Түвшин	Карбонатгүй	Сул карбонаттай	Дунд зэрэг	Хүчтэй карбонаттай	Маш хүчтэй

д) Хөрсөн дэх давсжилт хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд цахилгаан дамжуулах чанар нь ургамлын ургац, ургамлын тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг байна.

Давсжилт	<0.75	0.75-2	2-4	4-8	8-15	>15
Түвшин	Давсгүй	Сул давстай	Дунд зэрэг давстай	Өндөр давстай	Маш өндөр давстай	Хэт их давстай

е) Хөрсөн дэх хөдөлгөөнт элементүүдийг Мачигин аргазүйгээр тодорхойлсон бөгөөд аргазүйдээ хангамжийг ангилсан байдаг (мг/100 гр).

Фосфор	<1	<1.5	1.5-3.0	3-4.5	4.5-6.0	>6.0	<10
Түвшин	Хэт бага	Бага	Дунд	Дунд-с их	Их	Хэт их	Хэт бага
Кали	<10	10-20	21-30	31-40	41-50	50<	<10
Түвшин	Хэт бага	Бага	Дунд	Дунд-с их	Их	Хэт их	Хэт бага

9.2.3. Судалгааны үр дүн

Хээрийн судалгаагаар авагдсан нийт дээжнүүдийн лабораторийн задлан шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, судалгааны цэгүүдийн хөрсний шинж чанарыг товч тодорхойллоо.

Хөрсний хүнд металл:

Хөрсний бохирдлын гол үзүүлэлт болох хүнд металлууд нь задарч алга болдоггүй хөрсөнд удаан хугацаагаар хадгалагдаж ус болон ургамлаар дамжин хүн, мал, амьтны организмыг хордуулдаг. Амьд организм буюу хүн, амьтны биед удаан хугацаагаар хуримтлагдсанаас организмыг молекулын ба гений түвшинд хордуулдаг.

Хүнд металл гэж: нягт нь 5г/см³-ээс илүү, атом масс нь 40-өөс илүү металлууд орно. Үүнд: Sc, Ti, V, Cr, Mn, Fe, Co, Ni, Cu, Zn, Ga, Rb, Sr, Y, Zr, Nb, Mo, Tc, Ru, Rh, Pd, Ag, Cd, In, Sn, Cs, Ba, La, Hf, Ta, W, Re, Os, Ir, Pt, Au, Hg, Pb, Bi, Po, At, Fr, Ra, Ac зэрэг 42 элемент багтана. Химийн хувьд хүнд металлууд гэсэн бүлэг дотор хортой элементүүдээс гадна, хор нөлөө нь бага биологийн идэвх багатай олон элементүүд багтдаг.


Хортой хүнд металл: хүн, амьтан, ургамлын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө үзүүлдэг, янз бүрийн өвчин үүсгэх эх үүсвэр болох ба эдгээрт: хар тугалга (Pb), зөөлөн цагаан (Cd), мөнгөн үс (Hg), хүнцэл (As), хром (Cr), зургаан валентат хром (Cr⁶⁺), цайр (Zn), кобальт (Co), никель (Ni), зэс (Cu), стронций (Sr), ванадий (V) зэрэг 12 металл орно.

Хүнцэл (As): металл биш боловч хортой аюул нөлөө нь хүнд металлуудтай төстэй учраас хүнд металл гэсэн бүлэгт багтдаг.

Онцгой хортой органик биш бодисууд (хүнд металл): хар тугалга (Pb), зөөлөн цагаан (Cd), мөнгөн үс (Hg), хүнцэл (As), хром (Cr), зургаан валентат хром (Cr⁶⁺), цианид (CN⁻). Эдгээр нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхэлд хүргэх аюултай.


Био-идэвхт хүнд металл: зэс (Cu), цайр (Zn), хром (Cr), ванадий (V), никель (Ni), стронций (Sr), цагаан тугалга (Sn), анзан (Mo), селен (Se), бор (B), фтор (F) багтах бөгөөд хортой нөлөөллийн хувьд онцгой хортой хүнд металлууд (Pb, Cd, Hg, As)-аас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу оргономол өвчин үүсгэдэг аюултай.

#	Лаб дугаар	Дээжийн дугаар	Дээжийн тод	Na	Ca	Mg	K	Fe	As	Ba	Be	Bi	Cd
1	10063	Кемп	Хөрс	1.57	6.63	0.46	2.97	1.77	19.6	805	<1.0	<10.0	<1.0
2	10064	У/ Карьер	Хөрс	1.48	2.64	0.44	2.39	1.92	8.97	700	<1.0	<10.0	<1.0
MNS 5850 : 2019 зөв/хэмжээ				-	-	-	-	-	20.0	-	-	-	3.0
MNS 5850 : 2019 хүлцэх агууламж				-	-	-	-	-	10	-	-	-	1
#	Лаб дугаар	Дээжийн дугаар	Дээжийн тод	Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb
1	10063	Кемп	Хөрс	6.67	16.4	11.88	44.26	30.3	365.4	<5.0	9.0	495.8	16.69
2	10064	У/ Карьер	Хөрс	7.47	18.71	11.71	16.53	14.95	422.9	<5.0	11.63	482.4	18.17
MNS 5850 : 2019 зөв/хэмжээ				50.0	150.0	100.0	-	-	-	5.0	150.0	-	100.0
MNS 5850 : 2019 хүлцэх агууламж				30	60	60	-	-	-	2	60	-	50
#	Лаб дугаар	Дээжийн дугаар	Дээжийн тод	Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr		
1	10063	Кемп	Хөрс	<10.0	<5.0	551.5	2500	36.16	14.42	44.17	70.68		
2	10064	У/ Карьер	Хөрс	<10.0	<5.0	311.0	2700	43.01	13.54	45.42	59.19		
MNS 5850 : 2019 зөв/хэмжээ				-	1000	800.0	-	150.0	20	300.0	-		
MNS 5850 : 2019 хүлцэх агууламж				-		600	-	100	-	100	-		



Зураг 9-1. Хүнцэлийн агууламж


Хүнцэл нь металл биш боловч хортой аюул нөлөө нь хүнд металлуудтай төстэй учраас хүнд металл гэсэн бүлэгт, онцгой хортой гэсэн ангилалд багтдаг. Нийт судалгаанд хамрагдсан талбайн хүнцлийн агууламж 8.97-19.6 мг/кг-ийн хооронд хэлбэлзэж байна. Монгол улсын стандартад заасан хүнцлийн хүлцэх агууламж 20 мг/кг, элсэнцэр хөрснийх 10 мг/кг гэж заасан байдаг. Нийт цэгүүдэд элсэнцэр хөрсний стандарт хүлцэх агууламжаас кемпийн хүнцэлийн агууламж их, зөвшөөрөгдөх агууламжаас бага байна.



Зураг 9-2. Хром (Cr)-ын агууламж

Хром (Cr) нь онцгой хортой хүнд металлын ангилалд хамрагддаг. Нийт судалгаанд хамрагдсан хөрсний дээжинд хром (Cr)-ын агууламж 16.4-18.71 мг/кг хооронд хэлбэлзэж байна. Хром (Cr)-ын Монгол улсад мөрдөгддөг хөрсний хүлцэх агууламжийн хэмжээ 150 мг/кг,

элсэнцэр хөрсний стандарт 60 мг/кг гэж заасан байдаг. Судалгаанд хамрагдсан дийлэнх дээжний хромын агууламж хүлцэх агууламжаас бага байна.



Зураг 9-3. Хар тугалга (Pb)-ны агууламж мг/кг

Хар тугалга нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл, сульфид байдлаар агуулагддаг. Хар тугалга нь хордлого үүсгэхдээ амьсгалын зам, залгих, арьс ба нүдэнд хүрэлцэх замаар дамжин даарч сульдах, нойргүйдэх, жингээ алдах, бүдүүн гэдэс рүү хатгах (colic), цус багадах, бугуй ба шагайн саа, тархины зовнил, бөөр өвдөх, нүд үрэвсэх, цусны даралт ихсэх зэрэг нөлөөлөл үзүүлдэг. Хөрсний судалгааны үр дүнгээс харахад хар тугалга (Pb)-ын агууламж 16.69-18.17 мг/кг хооронд хэлбэлзэх ба дээжинд элсэнцэр хөрсний хүлцэх агууламжаас бага түвшинд байна.

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

10.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчин аялал жуулчлалын яамаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав.

10.2. Кэмпийн оршин суугч болон автобаазын ажиллагсдад байгалийн ургамал талхлахгүй олон салаа зам үүсгэхгүй байх, шатах тослох материалын асгаралтын үед авах арга хэмжээний тухай болон бусад байгаль орчны холбогдолтой заавар зааварчилгаа, нийт ажиллагсдад ХХАА-ны ээлжит зааварчилгаагаар орох

Тайлангийн осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн хэсэгт дэлгэрэнгүй тусгаж өгсөн.

10.3. Орон нутгаас ажилтан авч ажиллуулах

Хүснэгт 10-1. Орон нутгийн ажилчдын мэдээлэл

Овог Нэр	Регистрын дугаар
Бээжинбат Гантулга	ЗК84110938
Цолмонбаатар Баярцэцэг	ЗФ88091202
Цолмонбаатар Пүрэвсайхан	ЗГ92062311
Мөнхбат Сүхбаатар	ЗИ87040611
Бадамгарав Энхнаран	ЗИ84092903
Дагвадорж Отгонхүү	ЗИ80032711
Дагвадорж Цолмонбаатар	ЗЮ61011719
Гүргэлсүрэн Жигмэдбат	ЗЖ66061800
Авид Өлзийбадрах	ЗГ69091016

10.4. Багийн иргэдийг өвөлжилт хүндэрсэн нэхцөлд өвс, тэжээлээр хангах

Хугацааны хувьд хэрэгжүүлэх болоогүй байна. Өвөлжилт хүндэрсэн нэхцөлд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах, өвс тэжээлээр дэмжихээр төлөвлөн ажиллаж байна.

10.5. Багийн иргэдээс уурхайн хүнсний хэрэгцээнд зах зээлийн үнээр мах худалдаалан авах

Орон нутгийн иргэдээс зах зээлийн үнээр мах, сүү худалдан авах орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих ажлыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна.

10.6. Төлөвлөгөөнөөс гадуур удирдалга зохион байгуулалтын түвшинд хийсэн ажлууд

1. Б. Бат-эрдэнийн олон улсын тэмцээний зардалд (2'300'000) хоёр сая гурван зуун мянга.

2. Дундговь аймгийн Өлзийт сумын 100 жилийн ойн хандивт (20'000'000) хорин сая

3. Дундговь аймгийн Өлзийт сумын оюутан Т. Бүжидмаад сургалтын төлбөр (4'100'000) дөрвөн сая нэг зуун мянга

4. Дундговь аймгийн Өлзийт сумын иргэн З. Эрдэнэ-Очирын эмчилгээний зардалд (1'000'000) нэг сая

5. Дундговь аймгийн Өлзийт сумын иргэн Бямбад эмчилгээний зардал (2'488'000) хоёр сая дөрвөн зуун наян найман мянга

2024 онд компанийн зүгээс удирдлага зохион байгуулалтын түвшинд (29'888'000) **хорин есөн сая найман зуун наян найман мянган төгрөгийг** хандивласан байна.

АРВАН НЭГ. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

10.1. Төрийн захиргааны төв байгууллагууд /Орон нутгийн БОАЖГ, бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар/

2024 оны хэрэгжилтийн тайланг Дундговь аймгийн Байгаль орчны газар болон Өлзийт сумын байгаль орчны байцаагч нарт хэвлэмэл байдлаар хүргүүлсэн.

10.2. БОАЖЯ-нд жилийн эцэст А/618 журмын дагуу орон нутгаас төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлтийг авч хавсарган төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлнэ

Байгаль орчны мэдээллийн санд оруулсан (еic).

10.3. Иргэд олон нийтэд хагас жил болон жилийн эцэст тайлангийн хэрэгжилтийг танилцуулах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, төслийн үйл ажиллагаатай холбоотой танилцуулга хийх, нөлөөллийн бүсийн иргэдтэй санал бодол солилцох ажлыг зохион байгуулан ажиллаа.




Зураг 10-1. Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалт



Зураг 10-2. Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалт

ХАВСРАЛТ

УБ-2	Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.	
	МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ	
2006.01.19 /Бүртгэсэн он, сар, өдөр/	2011004028 /Улсын бүртгэлийн дугаар/	
	2104989 /Регистрийн дугаар/	
Эрдгео	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/		
Дүрэм /Үүсгэн байгуулах баримт бичиг/		
Шийдвэр /шийдвэрийн нэр/	001 /дугаар/	1998.03.05 он, сар, өдөр
742100 /код/	Геологи хайгуулын ажил эрхлэх /Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/	
511001	Гадаад, дотоод худалдаа	
524000	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ	
/код/		
/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/		
Хугацаагүй хугацаа	1 /жишүүдийн тоо/	3,000.0 /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/
Орхон, Баян-Өндөр, Оюут, МСҮТөв - 220 тоот, утас1:23696, утас2:99352445, факс:		
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/		
		
Орхон аймгийн татварын хэлтэс /бүртгэсэн байгууллагын нэр/		

Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан, тэмдэг
Голомт Эрдэнэт салбар	Төгрөгийн	4001020084	А.Дэнсмаа
Голомт Эрдэнэт салбар	Валютын	4001058489	А.Дэнсмаа
ХХБ Баянзүрх 804 салбар	Төгрөгийн	404023587	А.Дэнсмаа
ХХБ Баянзүрх 804 салбар	Валютын	404050690	А.Дэнсмаа

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэсэн Ажилтан, тэмдэг
1	Шинэчлэсэн дүрэм бүртгэв.	2012.06.29	Л.Батцэцэг
